

Бодитой мэдээлэлд үндэслэсэн зөв хүлээлттэй байх нь чухал

Гадаад эдийн засгийн орчин болон бусад асуудлаар Монголбанкны Валют, эдийн засгийн газрын Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтсийн захирал С.Болдтой ярилцлаа.

Гадаад худалдаа өсч байгаа, ер нь цаашдын төлөв хандлага нь ямар байх вэ?

Эдийн засгийн өсөлтийн хүлээлт эерэг, хувийн хэвшлийн үйл ажиллагаа идэвхтэй, бизнесийн мөчлөг өссөн, экспортын бүтээгдэхүүний гадаад эрэлт тогтвортой, ашигт малтмалын томоохон төслүүд хэрэгжиж байгаатай уялдан гадаад худалдааны нийт эргэлт оны эхний 10 сард жилийн 90 хувийн өсөлттэй буюу 4.3 тэрбум ам.доллараар нэмэгдсэн. Үүний дотор экспорт 67 хувиар өсөхөд нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн биет хэмжээ болон үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Гэхдээ бараа бүтээгдэхүүний эрэлтийн дийлэнх хэсгийг импортоор хангадгаас бизнесийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр манай улсын импорт бас хурдацтай өссөөр байгаа юм. Ерөнхий хүрээгээр нь авч үзвэл экспортлох бүтээгдэхүүний гадаад эрэлт өндөр хэвээр байхын сацуу импортын эрэлт хэрэгцээ их, түүнчлэн гадаад худалдааны нөхцөл тааламжтай байгаа зэрэг нь барааны гадаад худалдаа цаашид өнөөгийн түвшнээс илүү өргөжин тэлэхэд нөлөөлнө.

Экспорт үлэмж хэмжээгээр өссөн байхад гадаад худалдааны алдагдал нэмэгдсэн нь юутай холбоотой вэ?

Хэдийгээр гадаад худалдааны нийт алдагдал оны эхний 10 сард 1.6 тэрбум ам.долларт хүрсэн ч, үүнээс бараа бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалт хэлбэрээр орж ирсэн импортыг хасч үзвэл төлбөр тооцоо нь валютаар хийгдсэн гадаад худалдааны алдагдал 441 сая ам.доллар байна. Энэ нь ирээдүйд бүтээмж болон экспортыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын шинжтэй буюу тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгслийн импортоос гадна нефтийн бүтээгдэхүүн, удаан эдэлгээтэй бараа бүтээгдэхүүн, мөн хэрэглээний шинжтэй импортын эрэлт дотоодын зах зээлд өндөр байгаатай холбоотой. Гэхдээ гадаад худалдааны алдагдал өсч байгаа ч, түүнийг санхүүгийн гүйлгээгээр эдийн засагт орж ирсэн валютаар буюу гол төлөв гадаадын шууд хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байгаа өнөөгийн хандлага хэвээр байна. Та бүхэн санаж байгаа бол өнгөрсөн онд цэвэр дүнгээр 1.6 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн. Энэ үзүүлэлт оны эхний 10 сарын байдлаар 3.4 тэрбум ам.долларт хүрч өсөөд байна. Үүнээс үзэхэд гадаад худалдааны алдагдал өссөн ч, түүнийг санхүүжүүлж буй эх үүсвэрийн хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад мөн нэмэгдсэн гэж ойлгож болно.

Та сая гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өссөн гэж хэллээ. Тэгвэл валютын урсгалын нийт хэмжээ өсч байна уу, аль эсвэл өнгөрсөн оноос буурсан уу?

Зөвхөн энэ оны эхний 11 сард эдийн засагт орж ирсэн болон эдийн засгаас гадагшилсан нийт валютын урсгалын эргэлт өнгөрсөн оноос 60 хувиар өссөн байгаа нь маш өндөр үзүүлэлт юм. Сүүлийн үед эдийн засагт орж ирэх нийт валютын урсгал буурсан гэх эндүү

ташаа ойлголт зарим хүмүүсийн дунд байна. Гэтэл валютын нийт орох урсгал өнгөрсөн оноос 47 хувиар өссөн, эдийн засагт цэвэр дүнгээр орж ирсэн валютын хэмжээ оны эхнээс 900 гаруй сая ам.доллартай тэнцэх хэмжээнд байна. Өөрөөр хэлбэл нийт эдийн засагт орж ирэх валютын хэмжээ нь эдийн засгаас гадагшлах валютаас давсан хэвээр л байгаа юм.

Сүүлийн үед зэсийн үнэ буурч байгаа учраас энэ нь эдийн засагт эрсдэл дагуулна гэсэн мэдээлэл нэлээд гарсан. Энэ талаар таны бодол?

Өнөөгийн байдлаар манай улсын нийт экспортын үнэ импортын үнээс 1.7 дахин өндөр байгаа нь гадаад худалдааны нөхцөл тааламжтай хэвээр гэдгийг нотолно. Гэхдээ АНУ, Евро бүсийн эдийн засгийн өсөлт удаашрахтай уялдан Хятад улсын экспортын эрэлт буурах, улмаар аж үйлдвэрлэлийн түүхий эд, суурь металлын үнэ, цаашилбал манай экспортын голлох бүтээгдэхүүний үнэ буурах вий гэсэн эрсдэл бас бий. Гэхдээ уг эрсдэл эдийн засагт ноцтой, ужиг нөлөөлөхгүй байх үндэслэл бас байна.

Тухайлбал ямар үндэслэлүүд байна гэж?

Нэгд, ирэх онд Хятад улсын эдийн засгийн бодит өсөлт 7-8 хувь, аж үйлдвэрлэлийн өсөлт дунджаар 9 хувьд байх, өөрөөр хэлбэл бүс нутгийн болон дэлхийн эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлтийг чирэх гол хөшүүрэг нь тус улс байх нь нэгэнт тодорхой билээ. Энэхүү өсөлтийг аж үйлдвэрлэлийн түүхий эд, суурь металлын хэрэглээний өсөлт дагах нь тодорхой. Хоёрт, Монгол улс Хятадын зэс болон төмрийн хүдрийн импортын 9 хувь, нүүрсний импортын 11 хувийг нийлүүлдэг ба экспортлох бүтээгдэхүүний үнэ болон чанарын аль аль талыг авч үзэхэд цаашид энэхүү хувь хэмжээг нэмэгдүүлэх бодит боломж манай улсад хангалттай бий. Тухайлбал, экспортын орлогын 43 хувийг бүрдүүлж байгаа нүүрсний экспортын дундаж үнэ маань өсч байгаа хэдий ч Австралийн нүүрсний экспортын үнэ болон Хятадын дотоодын зах зээл дэх үнээс хамаагүй доогуур байдаг. Үүнээс үзэхэд нүүрсний экспорт үнийн хувьд өрсөлдөх чадвартай бөгөөд цаашид ч үнэ нь өсөх бололцоотой гэж үзэх үндэстэй. Гуравт, оны эхнээс 12 дугаар сарын 2-ныг дуусталх хугацаанд Лондоны металлын бирж дэх А-зэрэглэлийн цэвэршүүлсэн зэсийн үнэ тонн нь 8912 ам.доллар байсан бөгөөд өнөөгийн 7900 түвшнээсээ буурч дунджаар 7000-7500 түвшинд хэлбэлзэж болзошгүй боловч нийт экспортын орлогод эзлэх зэсийн баяжмалын экспортын хувь хэмжээ буурч 20 гаруй хувьд хүрснээс үзэхэд зэсийн үнийн болзошгүй үнийн бууралтыг нүүрс, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ болон үнийн өсөлтөөр нөхөх, ингэснээр эдийн засаг дахь нөлөөлөл нь харьцангуй бага байх боломжтой. Ер нь эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тодорхой бус эмзэг байдал, эрсдэлтэй уялдан хэт хөөрөгдөж өссөн зэсийн үнэ өнөөгийн нөхцөлд зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, эдийн засгийн суурь үзүүлэлтээр тодорхойлогдох бодитой түвшиндээ хүрсэн гэж хэлж болно.

Валютын ханш өссөн талаар ямар тайлбар өгөх вэ? Ер нь яагаад төгрөгийн ханш суларч байгаа вэ?

Өнгөрсөн онд төгрөг ам.долларын эсрэг 13 хувиар чангарсан бол энэ оны эхнээс 7 орчим хувиар суларсан үзүүлэлттэй байна. Хэдий тийм боловч 2010 оны эхнээс авч үзвэл төгрөг ам.долларын эсрэг 6 хувиар чангарсан гэсэн үг. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш энэ оны эхнээс дунджаар 1256.77 төгрөг байгаа нь

өнгөрсөн оны дундаж ханшаас 108 төгрөгөөр 8 хувиар чангарсан үзүүлэлттэй байна. 2011 он гарсаар нийт валютын урсгалын эргэлт, далайц нь өнгөрсөн оноос огцом өссөн байхад төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш оны эхнээс нэг өдөрт дунджаар маш бага хэмжээгээр буюу 0.24 хувиар л хэлбэлзсэн байгаа.

Эдийн засаг дахь валютын нийлүүлэлт өнгөрсөн онтой харьцуулахад өсч байгаа ч зах зээлд богино хугацаанд валютын эрэлт өссөнтэй уялдаад төгрөгийн валюттай харьцах ханш алгуур суларсан гэж ойлгож болно. Импортын эрэлт өссөөр байгааг өмнө хэлсэн. Эдийн засаг тэлж, мөнгөний нийлүүлэлт өсч, хүмүүс орлоготой болохын хэрээр импортын хэмжээ өсч байна. Хүмүүс хуримтлалаа нэмэгдүүлэх бус харин хэрэглээгээ нэмээд л байвал импорт дагаад л өснө. Бараа бүтээгдэхүүний импортын өсөлтийг дагаж тээврийн зардал зэрэг үйлчилгээний төлбөрүүд бас нэмэгддэг. Гэхдээ эдийн засаг дахь орсон ба гарсан валютын урсгалын хэмжээ тэнцвэртэй буюу цэвэр дүнгээр эдийн засагт орж ирэх валютын хэмжээ илүү давамгайлсан хэвээр байгааг дахин хэлье.

Хүмүүс валютын ханшийн талаар янз бүрээр л ярьж байна. 20 дугаар тогтоол шиг юм болно гэж нэг хэсэг шуугисан. Зарим хүмүүс ирэх онд их хэмжээний валют орж ирэхээр төгрөгийн ханш эргээд чангарна гэх юм. Цаашид хандлага ер нь ямар байх бол?

Макро эдийн засгийн төлөв хандлагаа харвал Монголд 20 дугаар тогтоол шиг зүйл болохгүй гэдэг нь тодорхой шүүдээ. Монголбанк ч энэ талаар удаа дараа мэдэгдэл хийсэн. Одоо иймэрхүү цуу үгэнд итгэж салхи дагаж хийсдэг үе өнгөрсөн гэж бодож байна. Төгрөгийн валюттай харьцах ханш хэдийгээр богино хугацаанд алгуур сулрах чиглэлд хэлбэлзэж байгаа ч валютын нийлүүлэлт огцом нэмэгдвэл хандлага нь өнөөгийнхөөс өөрчлөгдөнө. Экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалтаас гадна Засгийн газар, Хөгжлийн банк бонд гаргаж зарим банк, компаниуд гадаад зах зээлээс хөрөнгө босгох замаар багцын хөрөнгө оруулалтыг дотоодын захад оруулж ирэн төгрөгт хөрвүүлэх тохиолдолд энэ нь төгрөгийн валюттай харьцах ханшийг чангаруулах чиглэлд нөлөөлж таарна. Тэгэхээр цаг цагаараа байдаггүй гэдэгчлэн төгрөгийн ханш валютын эсрэг бас нэг л чиглэлд хэлбэлзээд байдаггүй. Валютын эрэлт, нийлүүлэлт ямар байхаас хамаарч ханш богино хугацаанд суларч, бас чангардаг.

Төгрөгийн ханш валютын эсрэг сулрах нь ямар нөлөөтэй байх вэ?

Юуны өмнө ханш сулрах, чангарах гэдгийн мөн чанарыг зөв ойлгох хэрэгтэй болов уу. Ханшид огцом хэлбэлзэл, савлагаа үүсэх нь хүсээд байх зүйл огт биш. Энэ ч үүднээс Монголбанк төгрөгийн валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг баримтлан ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр шаардлагатай үед нь захад оролцож зохицуулалт хийдэг. Зөвхөн гадаад худалдааны тухайд авч үзвэл төгрөгийн ханш валютын эсрэг сулрах нь экспортлогчдын төгрөгөөр илэрхийлсэн орлого нэмэгдсэнээр дахин хөрөнгө оруулалт хийх боломж өсөх сайн талтай. Харин импортлогчдын хувьд импортын барааны үнэ өсөх магадлалтай ба тэр хэмжээгээр импорт илүү зардалтай болно. Гэтэл төгрөгийн ханш валютын эсрэг чангарахад эсрэгээрээ экспортлогчийн төгрөгөөр илэрхийлэгдсэн орлогын хэмжээ буурч, бараа бүтээгдэхүүн импортлох сонирхол улам нэмэгдэнэ. Статистик дурдахад оны эхний

10 сард импортын нийт хэмжээ өнгөрсөн оноос 111 хувиар огцом өсч 5.4 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд үүний 51 хувийг хүнд машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, нефтийн бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл эзэлж байна. Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн зэсийн баяжмалын экспортын орлогоос бага оврын ачааны болон суудлын автомашины импортын төлбөр давсан үзүүлэлттэй байна гэдгийг санууштай. Нэг талаас удаан эдлэгдэх бүтээгдэхүүний импорт нэмэгдэж хүмүүсийн хэрэглээ өсч байгаа ч, нөгөө талаас өсөн нэмэгдэж буй импорт маань үр ашигтай байж чадаж байна уу гэдэг бодох ёстой чухал асуудал. Ирээдүйд валютын орлого олох үйлдвэрлэл, бүтээмжийг өсгөх хөрөнгө оруулалтын шинжтэй импорт нэмэгдэж байгаа нь маш эерэг үзүүлэлт билээ. Гэтэл үүний зэрэгцээгээр үр ашиг муутай, хэрэглээний шинжтэй импорт урт хугацаанд өсөх нь дотоодын үйлдвэрлэл, түүний ирээдүйд сөрөг нөлөөлнө. Бүтээмжийг өсгөхгүй, үрэлгэн шинж чанартай импортыг зохистой хазаарлах зах зээлийн зохицуулалт, тохиргоог ханш л өөрөө хийдэг.

Төгрөгийн ханш зах зээлийн нөхцөлөөс хамаарч тогтох юм байна. Тэгвэл ханшийн эрсдэлийг яаж удирдаж зохицуулах боломж байна вэ?

Валютаар төлбөр, тооцоо хийдэг байгууллагууд ханшийн эрсдэлээс хамгаалах бүтээгдэхүүн, санхүүгийн үүсмэл хэрэгслийг харилцагч банкнаасаа шаардаж хэрэглэж дадах хэрэгтэй. Энэ төрлийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд банкууд илүү идэвхтэй ажиллах шаардлагатай. Хэдийгээр санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээл Монголд үүсээд удаагүй ч, банкууд болон харилцагч этгээд хооронд ханшийн эрсдэлээ удирдах арга хэрэгслийг улам бүр хөгжүүлж байж л системийн хэмжээнд эрсдэлийг бууруулна. Төгрөгийн ханш валютын эсрэг чангарвал баярладаг, суларвал уурладаг, бусдаас бурууг хайдаг байж таарахгүй. Бизнес хийж буй этгээд зах зээлийн эрсдэлээ өөрөө удирдаж сурах ёстой. Харин бизнесийн эрсдэлээ оновчтой удирдахад нь туслах зорилгоор үнэн бодитой мэдээлэл өгч, аль болох тогтвортой орчинг бүрдүүлэхийн төлөө бодлого хэрэгжүүлэх нь төрийн байгууллагын үүрэг юм.

Эцэст нь хүмүүст хандаж юу хэлэх вэ?

Хүмүүс аливаа эрсдэлээс болгоомжлох нь зөв л дөө. Гэхдээ хамгийн гол нь үнэн бодитой мэдээлэлд үндэслэсэн маш зөв хүлээлттэй байж, аливаа дэл сул ярианд итгэхгүй, айдсаас болж буруу шийдвэр гаргахгүй байх хэрэгтэй байна. Төгрөгийн валюттай харьцах ханшийн тухайд л гэхэд хэлбэлзэл нь зөвхөн нэг чиглэлд чангардаг, эсвэл сулардаг гэсэн туйлын ойлголт хаана ч байхгүй гэдгийг давтан хэлмээр байна. Олон нийтийн дунд төгрөг ам.долларын эсрэг тасралтгүй чангарах юм шиг, эсвэл байнга сулрах юм шиг маш буруу хүлээлт заримдаа үүссэн байдаг. Тэгвэл энэ буруу хүлээлт тань таныг эрсдэлд оруулна гэдгийг санах нь зүйтэй. Ерөөс ямарваа буруу хүлээлт захыг өөрийг нь гажуудуулдаг, захад оролцогчдыг эрсдэлд оруулдгийг бодолцож, аль болох бодит мэдээлэлд үндэслэж шийдвэр гаргах нь зохистой юм. Нэг үеэ бодвол үнэн бодитой байдлыг нь нягталсан, цаг хугацааны хувьд хоцрогдол багатай, олон улсын түвшинд тавигддаг шаардлагад нийцсэн, зөв шийдвэр гаргахад зайлшгүй шаардлагатай статистик мэдээллүүд захад оролцогчдод хангалттай байдаг болсон шүүдээ. Зүй нь тэдгээр мэдээллийг хүмүүс сайтар хэрэглэх нь чухал байна гэж хэлье.